

  
**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ**

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 64/А/1290315

Мандалговь

**Төлбөр барагдуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Адаацаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитаар сангийн хөрөнгөөр хийгдсэн "Цамхагт гэрэл тавих" ажлын төсөвт тусгагдсан **929,080.00** /Есөн зуун хорин есөн мянга ная/ төгрөгийн захиалагчийн хяналт, магадалшгүй ажлын зардлыг гүйцэтгэгч байгууллагад олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Засгийн газрын 2023 оны 278 тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.2.5.-д /төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх;/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т /Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно./, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.1-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон **929,080.00** /Есөн зуун хорин есөн мянга ная/ төгрөгийг Дундговь аймгийн Адаацаг сумын Төрийн сан банк дахь орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн 100081552400 тоот дансанд 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг дарга

<sup>1</sup> Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

Ч.Уранчимэг, Засаг даргын орлогч Х.Нямцэцэг, Санхүүгийн албаны дарга  
Э.Баяржаргал, нягтлан бодогч Ө.Уранбилэг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АХЛАХ АУДИТОР

Д.ИХБАЯР

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

